

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

## НЭГ. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, УИХ болон УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Эрх зүйн актын биелэлтийн хувийг тооцоходоо Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон ашигласан болно.

Эрх зүйн актын зүйл, заалтын агуулга жил бүр давтагдах шинж чанартай бол тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа.

## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН

### 3.1. Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтын тоо

ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд 2024 оны жилийн эцсийн байдлаар байршуулсан яамны үндсэн чиг үүрэгт хамааралтай Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, УИХ болон Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, тэмдэглэл нийлсэн нийт 166 хууль, тогтоол, шийдвэрийн 308 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

### 2.2. Үнэлгээний дундаж дүн

Хяналтад авсан 308 заалтын 279 нь “үр дүн гарсан” буюу 100%, 15 заалт “хэрэгжих шатанд” буюу 70%-ийн хэрэгжилттэй, хугацаа болоогүй 14 заалт, нийт хэрэгжилтийн дундаж 98.5 хувьтай үнэлэгдэв.

Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнг 1-р хүснэгтэд үзүүлэв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэгдсэн дүн  
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

Бүгд		Шийдвэрийн төрлөөр										
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	
Хяналтад авсан тогтоол шийдвэрийн тоо	166	8	17	9	2	4	1	47	71	71	3	
Заалтын тоо	308	21	42	13	3	6	1	64	137	137	17	
Үнэлгээ	Биелсэн /100%/	279	19	37	12	3	5	1	63	122	122	13
	Хэрэгжих шатанд /70%/	15	1	2	-	-	1	-	1	6	6	4
	Хэрэгжилт хангалтгүй /30%/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хугацаа болоогүй	14	1	3	-	-	-	-	-	9	9	-
Үнэлгээ /хувь/	98,5	98,5	98,4	100	100	95	95	100	98,5	98,59	92,9	

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

4.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт дунджаар 2024 оны жилийн эцсийн байдлаар 98,5 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байна.

4.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн үнэлгээгээр хэрэгжилт үргэлжилж байгаа болон хугацаа болоогүй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган яамны газар, хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулсан.
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх сарын аяны удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, удирдамжийг холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлж, 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Удирдамжийн дагуу газар, хэлтсүүд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2 удаа тооцож тайлагнасан.
- 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хойш яамны цахим системд бүртгэсэн нийт 92 тогтоол шийдвэрийн 152 заалт тус бүрт хяналтын карт хөтлөн холбогдох газар, хэлтсийн даргад хүлээлгэн өгч сар бүр биелэлтийг авч байнгын хяналт тавин ажилласан.

4.3. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, шинэ суурьшлын бүсийг бий болгох зорилго бүхий УИХ болон Байнгын хорооны 2 тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны 1 тэмдэглэл, Засгийн газрын 3 тогтоол, Ерөнхий сайдын 2 захирамж, Засгийн газрын хуралдааны 4 тэмдэглэл тус тус батлагдан гарсан байна. Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот, Төв аймгийн Хөшигийн хөндийд шинэ дагуул хот байгуулах тухай тогтоол шийдвэр гарч, шинэ бүс бий болгох ТЭЗҮ, тооцоо, судалгаа, төлөвлөлтийн ажлууд хийгдэж инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, мэдээлэл холбоо, цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах ажлууд дуусч бүтээн байгуулалтын ажил эхэлсэн нь нийт тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд ахиц гарахад нөлөөлсөн гэж дүгнэв.

## ТАВ. ЗӨВЛӨМЖ

5.1. ХШҮ-ний нэгдсэн дүнгээр хэрэгжилт үргэлжилж байгаа 70 хувийн үнэлгээтэй болон хугацаа болоогүй арга хэмжээг хэрэгжүүлэх талаар анхаарч 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга нарт;

5.2. Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг ББМБЗГ-т;

5.3. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл батлах тухай”, “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газарт танилцуулж ажиллахыг ХББЗГ-т;

5.4. Нэг удаагийн шинж чанартай, хугацаа дууссан, үйл ажиллагаа нь өөр төрийн захиргааны төв байгууллагад шилжсэн болон цаашид хэрэгжих боломжгүй болсон тогтоол шийдвэрүүдийг тухай бүрт нь хяналтаас хасуулах тал дээр анхаарч, ХШҮДАГ-тай хамтарч ажиллаж хэвшихийг яамны газар, хэлтсийн дарга нарт тус тус зөвлөмж болгож байна.

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР